



# ASIA PACIFIC SECURITIES

BROKER DEALER AND UNDERWRITING COMPANY

2015 оны 4 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар: 3.

Улаанбаатар хот

## “ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОММИССЫН ТОГТООЛ

*Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай*

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2 заалт, 72.1.3 болон 75.4 дэх хэсэг, санал хураах хуудсаар кумулятив аргаар өгсөн саналыг тоолсон дүнг хэлэлцэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр сонгуулахаар нэр дэвшсэн хүн тус бүрээр кумулятив аргаар өгсөн саналын тоо нь дараах байдалтай байгааг хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлсүгэй.

Нэг.Ердийн гишүүд

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр Дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн Саналын эрхийн тоо
1. Цэрэндорж Төмөр	1,510,921 (17.11%)
2. Чимэддорж Долгормаа	1,510,855 (17.11%)
3. Төмөр Дарима	1,510,855 (17.11%)
4. Батжаргал Батбаяр	1,432,316 (16.22%)
5. Батбаяр Батхишиг	1,432,315 (16.22%)
6. Батбаяр Баттөр	1,432,314 (16.22%)
7. Минжин Бат-Оргил	0 (0.00%)



# ASIA PACIFIC SECURITIES

BROKER DEALER AND UNDERWRITING COMPANY

Тус тус санал авсанаар дараах нэр бүхий гишүүд сонгогдов. Үүнд:

ТУЗ-ийн ердийн гишүүдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн Саналын эрхийн тоо
1. Цэрэндорж Төмөр	1,510,921 (17.11%)
2. Чимэддорж Долгормаа	1,510,855 (17.11%)
3. Төмөр Дарима	1,510,855 (17.11%)
4. Батжаргал Батбаяр	1,432,316 (16.22%)
5. Батбаяр Батхишиг	1,432,315 (16.22%)
6. Батбаяр Баттөр	1,432,314 (16.22%)

Хоёр.Хараат бус гишүүд

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн Саналын эрхийн тоо
1. Хангай Алтай	2,148,825 (48.67%)
2. Буянбадрах Баянмөнх	105 (0.002%)
3. Оргой Буяннэмэх	1,132,911 (25.66%)
4. Балхаажав Бүүвэй	1,132,947 (25.66%)
5. Ширмэнхуяг Ууганжаргал	0 (0.00%)

Тус тус санал авсанаар дараах нэр бүхий гишүүд сонгогдов.Үүнд:

ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн Саналын эрхийн тоо
1. Хангай Алтай	2,148,825 (48.67%)
2. Оргой Буяннэмэх	1,132,911 (25.66%)
3. Балхаажав Бүүвэй	1,132,947 (25.66%)

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



*[Handwritten signature]*

Н. БАТЖИН

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН

*[Handwritten signature]*

Т. ЯНЖИНДУЛАМ



Гутал ХК-ийн Хурлын материал тараах

Үнэт цаас: 88-Гутал

Зарласан ширхэг:

1,618,684

Комисс: Азия Пасифик Секьюритис ҮЦК

Гаргасан ширхэг:

1,618,684

1	ҮЦК код	ҮЦК нэр	Материал тоо	Огноо	Хүлээн авсан нэр	Хүлээж авсан гарын үсэг
2	2	Масдак		2015-03-18	М.Бүрмэдүр	
3	3	Гүмэн булл	5	2015.3.19	Х. Сайнбаяр	
4	4	Санар	1	2015-03-18	М.Бүрмэдүр	
5	5	Зэргэд	2+3	2015.03.19	М.Бүрмэдүр	
6	6	Мэргэн санаа	10	2015-03-19	М.Бүрмэдүр	
7	7	Бидисек	5	2015.3.19	Х. Сайнбаяр	
8	7, 27	Орчил инвест + Аргай бест	3	2015.3.18	Ариунболд	
9	9	Өндөрхаан инвест	1	2015-3-19	М.Бүрмэдүр	
10	10	Алтан Хоромсог	1	2015.3.19	М.Бүрмэдүр	
11	12	Хөвсгөл бирж + ГЧ		2015.3.19	Бүтгэл	
12	13	Булган	2	2015.03.18	Б.Баярсайхан	
13	14	Ажнай инвест		2015-03-18	М.Бүрмэдүр	
14	15	Дархан	2	3.19	Оршгоо.Н	
15	16	Хайрхан Өндөрхаан	1	2015-3-19	М.Бүрмэдүр	
16	17	Эрдэнэст	2	20		
17	18	Монсек		2015-03-19	М.Бүрмэдүр	
18	19	Тулгат чандмань баян	3	2015-03-19	М.Бүрмэдүр	
19	20	Мөнхөд - ГЧ		2015.3.19	Бүтгэл	
20	21	Бумбат алтай	5	2015-03-19	М.Бүрмэдүр	
21	22	Азия Пасифик Секьюритис	2	2015.03.19	М.Бүрмэдүр	
22	23	Лог	1	2015-03-18	М.Бүрмэдүр	
23	25	Таван богд	2	2015-03-19	М.Бүрмэдүр	
24	26	Шанд Эрдэнэ	1	2015-03-18	М.Бүрмэдүр	
25	28	Очмөнх	2	2015.3.19	М.Бүрмэдүр	
26	29	Дэлгэрхангай секьюритиз	4	2015.3.19	М.Бүрмэдүр	
27	29	Дэлгэрхангай секьюритиз				
28	30	Ники	4	2015.3.19	Х. Сайнбаяр	
29	31	Гендекс	1	2015.03.19	М.Бүрмэдүр	
30	32	Монет Капитал	1	2015-03-19	М.Бүрмэдүр	
31	35	Толин секьюритис				
32	42	Ханш Инвест	4	2015.3.19	Х. Сайнбаяр	
33	43	Монгол секьюритис	1	2015-03-19	Б.Баярсайхан	
34	44	ACE & T capital	1	2015	М.Бүрмэдүр	
35	45	Батс	1	2015.3.19	М.Бүрмэдүр	

47	Нэйшнл секьюритис	2	2015.03.18	Б. Гун	Б. Гун
37	49 Блүмсбюри (Английн)		2015.03.18	Г. Холбоо	Г. Холбоо
38	50 Ди си эф		2015.03.18	Г. Холбоо	Г. Холбоо
39	52 Тэнгэр капитал	2	2015.03.18	Г. Холбоо	Г. Холбоо
40	57 Ард капитал	2	2015.3.19	У. Ногоо-Урал	У. Ногоо-Урал
41	58 Эм ай би жи	2	2015.3.19	Б. Анхандорж	Б. Анхандорж
42	62 Евразиа капитал холдинг	1	2015.3.18.	Б. Наранцагзори	Б. Наранцагзори
43	64 Гүүдсек		2015.3.19.	Бүтгэл	Бүтгэл
44	68 Превалент			Наранцагзори	Наранцагзори
45	69 Эм даблү ти эс	2.	2015.3.18	Б. Гун	Зоригтгал
46	71 Ти ди би копитал		2015.3.18	Наранцагзори	Наранцагзори
47	74 Юу жи эс				
48	75 Новел				
49	100 Стандарт инвестмент	2. и	2015.03.19	У. Чингэс	У. Чингэс
50	ҮЦГТТХТ ТӨХХК				
51	СЗХ				
52	МХБ				







100



Б.Мөнхэрдэнэ © POCUS /N

9400 орчим нь төрийн болон төрийн бус өмчийн 75 цэцэрлэгт хамрагдаж байна. Өөрөөр хэлбэл, 2-5 насны хүүхдүүдийн 70 хувь нь цэцэрлэгт явдаг. Энэ тоог нрэх хичээлийн жил 80 хувьд хүргэхээр зорьж байна. Цэцэрлэгтгүй хоёр хорооны нэг нь цэцэрлэгтэй боллоо. Цэцэрлэгтгүй 16 дугаар хороонд 240 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг барих ажил энэ жил эхэлнэ. Хөрөнгө нь батлагдсан. Цааш...

**"ГҮТАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт** Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, компанийн байранд болно.

**Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ.**

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт.
2. Компанийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудиторын дүгнэлт.
3. Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох.
4. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох.
5. 2014 оны ногдол ашиг
6. ТУЗ-ийн төсөв батлах
7. Компанийн үндсэн хөрөнгийн өнөөгийн байдал

Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөр тогтоосон болно.

Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох материал болон саналын хуудастай өөрийн харилцааг брокер диллерийн компани дээр танилцаж, саналын хуудсаа бөглөн, хувьцаа эзэмшигчдийн хуралдаа оролцоно уу.

Хурлыг "Азия Пасифик Секьюритис ҮЦК" ХХК зохион байгуулан явуулна.

**Утас: 7730-0660, 99061467, 99906877**

Та бүхэн ажлын бүх өдрүүдэд ажлын цагаар элгээр утсаар холбоо барьж болно.

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
АНХААРАЛД**

"Монгол керамик" Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2015 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 9 цагт** Улаанбаатар хот, СХД 14-р хороо, "Цамбагарав" үйлчилгээний төвийн баруун талд "Номын сан"-гийн байранд хуралдана.

**Хэлэлцэх асуудал:**

1. Компанийн үйл ажиллагааны тайлан, 2014 оны санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх.
2. ТУЗ болон ХЗ-ийн тайлан, 2015 оны төсөв төлөвлөгөөг хэлэлцэж батлах.
3. Хөрөнгө оруулалтын талаар хэлэлцэж батлах
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.
5. ТУЗ, ХЗ-ийн гишүүдийг сонгож батлах.

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй "Цамбагарав" үйлчилгээний төвийн



## “Гутал” ХК-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурал 2015 оны 4-р сарын 30-ны өдрийн 10<sup>30</sup> минутанд эхэлсэн. Хуралд Гутал ХК-ны ТУЗ-н дарга Б. Батбаяр, хувьцаа эзэмшигч Б. Батхишиг, хувьцаа эзэмшигч Ц. Төмөр, хувьцаа эзэмшигч Ч. Долгормаа, хувьцаа эзэмшигч Т. Дариймаа, хувьцаа эзэмшигч Х. Цэнд хувьцаа эзэмшигч Б. Батбилэгийн итгэмжлэлээр Б. Ганзориг, хувьцаа эзэмшигч Б. Баттөрийн итгэмжлэлээр Б. Баянмөнх, хувьцаа эзэмшигч Бидлсек БДК-ыг төлөөлж Батжин оролцож байна. Хурлыг нээж Б. Батбаяр: Та бүхнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэнд баярлалаа. Хурал нийт хувьцаа эзэмшигчдийн 90,91%-ын ирцтэйгээр хүчин төгөлдөр эхэлж байна. Жижиг хувьцаа эзэмшигчдээс төлөөлөл болж 3-н хувьцаа эзэмшигч ирсэн байна. Бидсек, хувьцаа эзэмшигч Х. Цэнд, Х. Нямдорж болон хурал зохион байгуулагч “Азиа Пасифик Секьюритис” ХХК-ний 3-н хүн ирсэн байна. Хурал нээснийг мэдэгдье. Хэлэлцэх асуудлаа дүрмийн дагуу батална. Гутал ХК-ын төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 3-р сарын 3-ны өдрийн 1-р тогтоолоор уг хурлыг хуралдахаар зарласан. 4-р сарын 30-ны өдөр хурлаа эхэлж байна.

Хуралд хэлэлцэх асуудлаа танилцуулъя:

1-рт Компаний 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангын талаар ТУЗ-ын гаргасан дүгнэлт

2-рт Компанийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт ✓

3-рт Компанийн ТУЗ-н ердийн гишүүдийг сонгох ✓

4-рт Компанийн ТУЗ-н хараат бус гишүүдийг сонгох ✓

5-рт Компанийн 2014 оны ноогдол ашигаа батлах ✓

6-рт ТУЗ-н 2015 оны зардалын төсвийг батлах ✓

7-рт Компанийн үндсэн хөрөнгийн өнөөгийн байдалтай танилцах ✓

гэсэн ийм 7-н асуудал хэлэлцэхээр ТУЗ-аас оруулсан. Энэ хэлэлцэх 7-н асуудлаа батлах уу? 100%-ийн саналаар гараа батлан өргөн баталлаа. Компанийн 2014-н оны үйл

ажиллагааны болон санхүүгийн тайлангын талаарх ТУЗ-н гаргасан дүгнэлтийг сонсьё. Илтгэлтэй холбогдуулан аудит асуух хувьцаа эзэмшигчид байна уу? Үйл ажиллагааны тайлантай холбогдуулан чөлөөтэй асуух хувьцаа эзэмшигчид асуулт тавья.

- Бидисек- Хөрөнгө оруулалт гэсэн хэсэг байна. Энэ нь Гутал ХК өөрийн хөрөнгөөр засаж сайжруулсан гэж ойлгох уу.
- Батбаяр- Тэгэж ойлгоно.
- Бидисек- Номин бол түрээслэсэн талбайгаа өөрийн хөрөнгөөр засаж сайжруулж орсон гэсэн үг үү!
- Батбаяр - Тэр бол 2012 онд Номин өөрийн хөрөнгөөр засаж сайжруулсан. Бусад нь бүгд өөрийн хөрөнгөөр.

Өөр асуулт байна уу. Асуулт байхгүй бол 2-р асуудалдаа орж 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг сонсьё. Дүгнэлтийг нягтлан бодогч Д. Алтанзул уншина.

- Алтанзул - 2014 оны санхүүгийн тайланг санхүүгийн зохицуулах хорооноос эрхтэй "Алаг уул Финанс" гэдэг аудитын компаниар баталгаажуулсан байгаа. Тус компанийн дүгнэлтээр хувьцаат компани нь 2014 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитын тайлан нягтлан Алтанзулд байсангүй хэсэг удав.

- Батбаяр - Тайлан тавихаа та мэдэж байсан уу
- Алтанзул - "Алаг Уул Финансын" дүгнэлтээр бол манай хувьцаат компанийн 2014 оны санхүүгийн тайлан нь олон улсын стандарт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу зөв бэлтгэгдэн тайлагнагдсан байна гэсэн дүгнэлт гарсан байна. Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зүйлийг Батбаяр гишүүн тавьсан учир би ганц 2 зүйл дээр тодруулга хийе. 2014 онд 2,9 тэрбумын орлоготой 1,4 тэрбумын зардалтай 1,4 тэрбумын цэвэр ашигтай ажилласан байна. Энэ бол татварын дараах ашиг Гутал ХК-ний өөрийн хөрөнгийн үндсэн хэмжээг өнгөрсөн онтой харьцуулахад 909,4 мянган төгрөг буюу 18,2 хувиар өсч 5,9 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт активийн хувьд 2014 онд 907,3 сая төгрөг буюу 17,2% өсч 6,2 тэрбум төгрөгт хүрсэн байгаа. 2014 онд тус компани нь нийгмийн даатгалын шимтгэлд 102,3, хувь хүнд



олгосон орлогын албан татвар 36,2 сул зогсолтоос хувь хүнд олгосон орлогын албан татвар 54,5 нэмэгдсэн өртөгийн албан татвар 272,9, аж ахуй нэгжийн орлогын албан татвар 177,9, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 48 сая төгрөг буюу нийт улсын төлөвт 691,9 сая төгрөгийг төлсөн байна. Аудитын дүгнэлтээр ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй стандартын дагуу бүртгэгдсэн байна гэж гарсан. Нэмж тодруулах зүйл байвал асууж болно.

- Батбаяр – тайлангаас асууж тодруулах зүйл байна уу?
- Бидисек – Борлуулалтын орлого түрүү жил 45 тэрбум байсан байна.
- Алтанзул – Энэ 45 гэдэг нь үндсэн үйлдвэрлэл буюу хэвлүүрийн цехийн орлого байгаа. Түрээсийн орлого нь 887,2 тэрбум. Одоо 22,4 сая гэсэн нь зөвхөн хэвлүүрийнх, Хулан цех нь 2013 онд үйл ажиллагаа байхгүй татан буугдсан байгаа.
- Бидисек – Нийт хэдэн м<sup>2</sup> талбай түрээсэлдэг вэ?
- Алтанзул- 40,000 орчим
- Бидисек- Үүний хэдэн хувь нь томоохон түрээслэгчдэд очдог вэ? Номин хэдэн м<sup>2</sup> вэ?
- Долгормаа- 20,000 гаран

Бидисек – Түрээсийн орлого 1,8-аас 2,8-н тэрбум болон өссөн. М<sup>2</sup> нь хэд байж байгаад хэд болсон бол?

- Алтанзул – Номин реалтортой хийсэн гэрээ 2013 онд хийгдээд тухайн жилдээ 7 сараас төлбөрөө авч эхэлсэн. 2013 онд 50% авч 2014 ондоо 100% авч эхэлсэн нь 2,8 тэрбум болохоор гол нөлөө үзүүлсэн нь
- Бидисек – Түрээсийн төлбөр нэмэгдээгүй хугацаат асуудлаас болсон юм уу?
- Долгормаа – Түрээс бол зарим нь нэмэгдсэн.
- Бидисек – Номингын гэрээний үнэ 18 жилдээ нэмэгдэх үү.
- Алтанзул – Өснө 3-н жилдээ 1 удаа үндсэн дүнгээс 12%-р нэмэгдэнэ.
- Бидисек – Үйл ажиллагааны зардалын 90 орчим хувийг ерөнхий ба удирдлагын зардал гэж байна. Үүний задаргааг тайлбарлаач
- Алтанзул – Нийт зардалын 37%-нь цалин, 4 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, ашиглалтан зардал 23%, элэгдэл 13%, бусад татвар 5%, бичиг хэрэг 0,3 хувь шуудан холбоо засвар 9%, цэвэрлэгээ 1%, тээврийн зардал 0,4%, шатахуун 1%, зар сурталчилгаа 0,3 хувь бусад зардал 5% эзэлж байна.
- Батбаяр- надад асуудал байна. Урт хугацаат хөрөнгө оруулалт хэзээ хийгдсэн бэ?
- Алтанзул – 2002 онд ТУЗ-ын дарга Батбаяр гишүүний тогтоолтойгоор



- Батбаяр- За ойлголоо. Олон жилийн өмнөх асуудлыг мартсан. Өөр зуух зүйл нь бусдаас авах авлага 944 сая төгрөг гэж байна. Энэ ямар авлага байна, хэдий хэд хугацаа өнгөрч байна.
- Алтанзул – Уг 940 саяын 350 сая нь Гутлын үйлдвэрт байх үеэс, 1996 оноос өмнөх үеийн асуудал, бусад нь ТУЗ-ын гишүүдийн авсан асуудал гэх мэт авлага байгаа. Түрээсээр үүссэн авлага байхгүй. 2010 оноос өмнөх үед үүссэн авлагууд байгаа.
- Батбаяр – 69 сая төгрөгөөр машин авсан гэсэн асуудал байна. Энэ жилийнх үү! 2014 онд худалдан авсан гэж байна.
- Алтанзул- 2013 онд худалдан авсан юм байхгүй. 2 машины граж барьсан асуудал байгаа.
- Бусад зардал 58,9 сая гэснийг тайлбарлаач
- Алтанзул- Нотариат, ажилчдийн хоол, компанийн үйл ажиллагаанд гардаг зардлууд
- Батбаяр- асуулт асууж дууссан бол асуултаа тасалж санал хэлэх хүмүүс байвал саналаа хэлье. Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай холбогдуулж саналаа хэлэх хүн байна уу?
- Батхишиг- Хувьцааны талаар мэдээлэл ороогүй байна.  
Санхүүгийн талаарх асуудлыг дараа дараагаар хуралдаа оруулж байвал зүгээр байна. Дансны үнийг хэлбэлзэл, хөдөлгөөний талаар
- Батбаяр Үүнийг дэмжиж байна. Улирал болон жилийн хөдөлгөөний талаар танилцуулах хэрэгтэй байна гэдгийг хүлээн авлаа. Өөр санал байхгүй бол би нэг юм хэлье. Аудитын тайлан хийлгэсэн "Алаг Уул" компанийг ТУЗ сонгоогүй шүү. Үүнийг удирдлага өөрөө сонгоод өөрийн хийсэн ажлаа тайлагнуулсан. Үүнийг цаашдаа анхаарах ёстой шүү. Энэ тайланг өөр аудитын байгууллага сонгуулж хийлгэх нь зүйтэй гэж үзэж байна.
- Алтанзул- Би тайлбар хэлмээр байна
- Батбаяр - Хугацаа алдсан шалтгаан байна.
- Алтанзул- Би хувийн аудитаа сонгоогүй гэдгээ хэлмээр байна.
- Батбаяр – хувийн биш ч байлаа гэсэн чи сонгох эрх байхгүй.
- Долгормаа- ТУЗ-ийн тогтоол гарсан шүү дээ
- Батбаяр –Ямарч тогтоол гараагүй
- Алтанзул- Би тайлбар хэлмээр байна. Би хувийн аудит сонгоогүй гэдгээ хэлмээр байна.



Энэ аудитын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудит мөн адил байхгүй байсан. Тийм учраас ТУЗ-ийн гишүүд болон 2014 оны 2 сарын 19ны хурлаар өөрсдөө уг аудитаа сонгосон. Сангийн яамнаас санхүүгийн программ өөрчлөгдөөд жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаа сонгож илгээдэг болсон. Хэрвээ тэрийг би илгээгээгүй бол санхүүгийн зохицуулах хороонд 20 сая төгрөгний торгууль төлөх байсан. Тэр торгуулийг би хүлээх үүрэггүй учраас, аудитын байгууллагийгч сонгох эрх үүрэг нь ТУЗ-д байдаг, уг үүрэг нягтлан бодогчид байдаггүй. 2 сарын 10-ны дотор ТУЗ аудитын хороог байгуулаад, уг хороо нь өөрсдөө уг аудитаа сонгох ёстой. Гэтэл бүх үүргийг надад өгчихөөд одоо ийм асуудал ярьж байгааг би зөвшөөрөхгүй байна.

- Батбаяр- Алтанзулд үүрэг өгөөгүй. Энийг сонго гэдэг үүргийг ТУЗ өгөөгүй. ТУЗ-аас ямарч тушаал тогтоол байхгүй. Ийм учраас дараагын ТУЗ сүүлийн 3 жилээрч юмуу маш нарийн хийлгэх ёстой гэж үзэж байна.
- Дариймаа нэг үг хэлчих үү. ТУЗ-нь энэ жил ямарч ажил хийгээгүй. Хэрүүл хийхээс өөр юм хийгээгүй. Тийм учраас өмнөх жил сонгогдсон компани автоматаар явж байгаа ТУЗ-ийн дарга нь хурлаа хийгээгүй, бичиг баримтаа бүрдүүлээгүй явчихаад одоо нягтланг хувийн чанраар олон хүний дэргэд ийм байдалд оруулах жоохон эвгүй юм.
- Батбаяр-ТУЗ-ийг ажиллах нөхцөл байдлын удирдлага гаргаагүй шүү. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг 3н удаа оруулсан баталж өгөөгүй.

Саналаа хэлсэн хүн нь саналаа хэлье

- Долгормаа – Би саналаа хэлье. Гутал ХК-нд 2014 онд яригдаагүй зүйл бол санхүүгийн зохицуулах хорооноос хувьцаа эзэмшигч Батбаярын хүсэлтээр 2 удаа шалгалт ирсэн. Эхний шалгалт үнэт цаасны газрын дарга Тулгаа, манай компанийг хариуцдаг Ичинноров мэргэжилтэн ирээд 2 зөрчил илрүүлээд тэрийг нь хувьцаа эзэмшигч Батбаяр хүлээн зөвшөөрөөгүй дахин шалгалт оруулна гээд өргөн хүрээтэй шалгалт 3 сард ирсэн юм. Тэд дахиад 14 зөрчилтэй акт тавиулсан. Дээрх гурван зөрчлийг арилгаагүй учир 19 сая төгрөгөөр торгуулаад Номингын гэрээг валютаар хийснийг солиулаад 9 сая төгрөгөөр торгуулсан байгаа. Гурван сард ирсэн санхүүгийн зохицуулах хорооны шалгалтаар 14 үүргийг 5 сарын 5-ны дотор зас гээд өгсөн байгаа. Үүний торгууль нь ирээгүй байгаа. Товчхон танилцуулахад ихэнх нь ТУЗ-ТАЙ холбоотой юм байна.



1рт ТУЗ-н үйл ажиллагааны журам гэдэг юмыг ТУЗ-сөө гаргаж батлуулаагүй байгаа.

2рт ТУЗ гэдэг тамгыг ТУЗ өөрөө хэлэлцээгүй гаргасан хувь эзэмшигчид хэлээгүй дур дураар, хууль бусаар хийлгэсэн байна.

3рт ТУЗ-н дарга Батбаяр ТУЗ-н нарийн бичгийн даргад шаардлага хангаагүй хүнээр дэвшүүлсэн учир манай ТУЗ бүхэн жил ТУЗ нарийн бичгийн даргагүй ажилласан.

- Батбаяр- Би дэвшүүлээгүй биш 3 удаа дэвшүүлсэн шүү
- Долгормаа – Шаардлага хангаагүй байгаа хүнийг дэвшүүлсэн учир. Ямарч байсан ТУЗ-ийн олонхийн санал авч чадаагүй учир ТУЗ нарийн бичиггүй ажилласан.

4рт ТУЗ-ийн 1 хараат бус гишүүнийг шаардлага хангахгүй байна гээд Бат-Оргил гишүүнийг өргөдөлөө өгөөд 2 сараар чөлөөлөгдсөн, үүнд нөхөх сонгууль хийгээгүй, хугацаа нь давчуу байсан учир

5рт ТУЗ –ийн хурлын дүрмээр өөрөөр заагаагүй бол сард 1 удаа хуралдуулах тэр заалтыг хийгээгүй гэсэн тиймд ТУЗ хангалттай ажиллаагүй гэсэн дүгнэлт гарсан байна.

6рт Компанийн засаглалын журмуудыг батлах ёстой. Үүнийг хэрэгжүүлээгүй гэж байна.

7рт ТУЗ-ийн хурлын тэмдэглэл хийдэггүй гэсэн зөрчил гарсан.

ТУЗ-ийн даргын ТУЗ –ийн саналаар томилно гэгчхээд аль нэг тийшээ ТУЗ-н шийдвэр гаргаж чадахгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулаад уг асуудлыг шийдээч гэсэн.

Ерөнхий захирлын ТУЗ-н гэрээнд заасан хэмжээнд цаашид ажиллах гэсэн санал өгсөн байна. Номингын гэрээг тооцооны нэгжээр бус төгрөгөөр хий гэсэн байна.

8рт Үл хөдлөх 2 гэрчилгээн дээр иргэн Төмөр "Гутал ХК-ний давхар нэр бичүүлсэн тухайн үед журмаараа ерөнхий захирлын нэр бичдэг байсан

8рт Ноогдол ашиг компанаараа биш үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр хийлгэн тараа гэсэн шаардлага тавьсан байна.

14рт Жилийн эцсийн аудитын тайланг хурлын хугацаанд хороонд ирүүлсэн гэсэн байна.

Аудитын компанийг жилийн эцэст юм уу 1 сард ТУЗ-өөрөө шийдчих асуудлын шийдээгүй хурлаар шийдэж өгөхгүй байсаар ийм асуудалд хүрсэн. Нөхөн ТУЗ-ийн тогтоол гаргаж "Алаг Уул" аудитыг сонгох тогтоол гарсан байгаа.



- ТУЗ- тай холбоотой асуудал санхүүгийн зохицуулах хорооноос гаргасантай холбоотой хувьцаа эзэмшигч миний бие ч бас цаашид ийм алдаа битгий гаргаасай гэж хэлэх гэсэн юм.
- Дарийма – 13-Н зөрчлийг 11 нь ТУЗ-ийн даргатай холбоотой гэдгийг хэлье.
- Батбаяр- Би сайн ойлголоо хувьцаа эзэмшигч 1 удаа үг хэлнэ. За Батхишиг үг хэлье
- Батхишиг- ТУЗ-ийн гишүүд хоорондоо хамтарч ажиллаж чадахгүй байгаа тохиолдолд яах ёстой вэ?
- Долгормаа- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Батбаяр- одоо хуралдаж байна үүгээр шийдье
- Долгормаа- Саналаа оруулаагүй учир саналаа гаргаж байна
- Батхишиг-Ажиллах ямарч боломж байхгүй байна
- Долгормаа- Санхүүгийн зохицуулах хороо энэ шалгалтыг нь хийж байна шүү дээ
- Батхишиг- Та 1 талаас нь буруугаар уншаад байна.1рт Асуудлын гол нь хамтарч ажиллаж чадахгүй байгаад байгаа эсвэл өөр хүмүүс санхүүгийн зохицуулах хорооноос тавих ёстой юм уу, яах ёстой юм бэ? Шийдвэр гаргаж чадах чадваргүй ТУЗ ажиллаад хэрэг байгаа юм уу?
- Долгормаа- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал компанийн дээд хурал
- Батхишиг-! Санхүүгийн зохицуулах хорооноос зөвлөмж авах ёстой юм уу. Энэ бүхнийг яаралтай шийдэх хэрэгтэй байна.Дараагийн ТУЗ үр бүтээлтэй байна гэж бодохгүй байна.Шийдвэр гаргаж чадахгүй байна. Энэ бүхэн бол 2 том хувьцаа эзэмшигчийн хоорондын асуудал үүнийг бүх хүн хэлж байгаа. Одоо бол бид ерөнхий захирлыг маш том шалгуураар тавина.
- Дарима – ТУЗ-ийн даргаа ч бас
- Батбаяр ТУЗ-н даргаа ч бас дахиж энэ 2 хүнийг тавихгүй гэсэн асуудал ярина. Ер нь энэ 2 гэр бүлээс тавихгүй. Хөндлөнгөөс тендер зарлаад санхүүгийн зохицуулах хорооноос байдаг юм уу тэгэж оруулна. ТУЗ-ийн гишүүдийг хурлийн дагуу томилно.Энэ бол миний бодол нягтланг энд тавихгүй. Ерөнхий захирал хэнийг тавина тэрний асуудал. Багаар ажиллах сайн засаглалын хэлбэрийг хэрэгжүүлэх нь чухал. Бидэнд тэр л дутагдаж байна.
- Долгормаа- Батхишигч байна уу Батбаяр ч байна уу хувьцаат компаний тухай хуулиар заагдсан зарчмыг нь ойлгодоггүй. Санхүүгийн зохицуулах хороо компаний тухай, хувьцаат компаний тухай хуулийг манай компани яаж хэрэгжүүлдэг вэ гэдэгт хяналт тавихаас хувьцаа эзэмшигчдийн өмнөөс ТУЗ юмуу ТУЗ-н дарга юмуу

ямарваа нэг шийдвэрийг зохицуулдаг байгууллага хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал.

- Батбаяр энэ хоёр гэр бүлийн гишүүд энэ компаний үйл ажиллагаанд оролцохгүй байх хэрэгтэй.
- Долгормаа дэд хороо байгуулдаггүй. ТУЗ-ийн дарга компанийн тухай ойлголт байхгүй, кодексийн тухай ойлголт байхгүй, хэрүүл хийдэг тийм байхгүй юу. Хараат бус гишүүдийг шалгуулъя, хувьцаа эзэмшигчдийн хурлыг дахин явуулъя.
- Батбаяр үүнийг хууль дүрмээр нь зохицуулж болно. Энэ хоёр гэр бүлийн гишүүд оролцохгүй байх ёстой. За даргын асуудалдаа орьё. Санхүүгийн зохицуулах хорооноос ирсэн асуудал дээр гол юм байна. Нийт 16 объектийг "Стент Ко" гэх Долгормаагийн компани руу шилжүүлсэн асуудал байна. 500,000 төгрөгөөр санхүүгийн зохицуулах хорооноос шалгаад хөрөнгийн бүртгэлийн газраас авсан материал дотор байж байна. Энэ нь 2013 оны 1 сарын 2 өдөр нийт 16 газрыг 1999 оноос өнөөдрийг хүртэл Улсын бүртгэлийн газраас 2015 оны 3 сарын 23-ний өдөр авсан материалд Гутал ХК нийт 16 улсын бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгө иргэн Ч.Долгормаа түүний хувийн компани "Стент Ко" ХХК, иргэн Ц.Төмөр энэ нь ерөнхий захирал шүү дээ. "Мөнхий Түншмэл" "Буурал Сутай" компанид үл хөдлөхийн гэрчилгээг түүний нэр дээр шилжүүлсэн байна. Энэ бол ноцтой асуудал шүү.
- Долгормаа, битгий гүтгээд байл даа
- Батбаяр- мэдэж байх тухай асуудлын талаар ярьж байна. Энэ 16 объектийг бид нэг бүрчлэн шалгаж үзнэ. Би бичиг явуулсан байгаа, одоо хүртэл надад ирээгүй. 2015 оны 4 сарын 21 өдөр А715 дугаартай бичгийг явуулсан, үүний шийдвэрийг явуулаачээ, ямар шийдвэрээр та нар хувьчилж авсан юм бэ.
- Долгормаа- бэлэн болсон байгаа
- Батбаяр- хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр байна уу, үгүй юу. Хамгийн гол нь ашиг сонирхлын зөрчилтэй улс уг шийдвэрийг гаргахад оролцох ёсгүй юм шүү. Ашиг сонирхлын зөрчилгүй улсуудын 75 хувь нь буюу үнэмлэхүй олонхоор хувьдаа авах, худалдах борлуулах ийм асуудал байгаа юм.
- Долгормаа- би яримаар байна. Энэ бол ердийн гишүүд хэнийг сонгох вэ? Гэдэг түүнтэй холбоотой ярьж байгаа байхгүй юу. Хувьцаа эзэмшигч Батбаяр Гутал ХК-ний үл хөдлөх хөрөнгийг шалгаачээ гэсэн
- Батбаяр- би гутлын байрнаас нэг ч газар аваагүй, нэг ч байшин аваагүй нэг ч үл хөдлөх эд хөрөнгө аваагүй. Энэ хоёр захирал бол бүгдийг нь авсан. 16 байрыг хувьдаа шүү



- Долгормаа: Батбаяр үл хөдлөх хөрөнгийг шалгаачээ гэхэд манайхаас зарагдсан юмнуудыг гаргаад, бүх ТУЗ-ийн тогтоолуудыг өгсөн байгаа. Та нарт хэлэхэд 1998 оноос ТУЗ-н заргаар Батбаяр хүн болон түүний гэр бүлийн улсууд даргаар томилогдоод байж байсан. Бүх ТУЗ-н тогтоолууд байгаа. Манай дүрмээр үл хөдлөх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдээд, шийдвэр гаргана гэдэг дүрмэнд байхгүй.
- Та бүхэнд товчхон хэлэхэд гүтгэдэг юм, шалгадаг юм, шалгаад өгөөч гэж гүйдэг юм. Тэгэхдээ хувьцаа эзэмшигчдийн дундын мөнгөнөөс торгуулийг нь төлдөг юм.

Батбаяр- шалгах нь зөв шүү дээ

Долгормаа: Манай компани 29-н сая төгрөгөөр, 9 сая нь Номингын гэрээтэй холбоотой, доллараар хийх үү, төгрөгөөр хийх үү, торгуулиа доллараар хийсэн гэж.

Батбаяр- та нар хий гэж зөвшөөрөл өгсөн болохоос биш гэрээг нь та нар хийсэн шүү.

Долгормааг- 20 сая төгрөгтэй холбоотой асуудал бол Батбаяртай холбоотой ТУЗ-тэй холбоотой ажлаа хийгээгүй асуудал байгаа шүү.

Батбаяр- дараагийн асуудалдаа орёе. Компанийн ердийн гишүүд болон хараат бус гишүүдийг танилцуулъя

- Алтанзул: Гутал ХК нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, 1605 бүхий санхүүгийн тайлан тэнцэл тусгаж байна. 2014 оны 12 сарын 31-ний байдлаар барилга байгууламж анхны өртөгөөр 4,5 тэрбум, хуримтлагдсан элэгдэл 1,8, үлдэгдэл өртөг 2,7 тэрбум байна. Машин тоног төхөөрөмж 0,2 тэрбум, хуримтлагдсан элэгдэл 65 сая. Үлдэгдэл өртөг 147 сая тээврийн хэрэгсэл 118 сая анхны байдлаар, элэгдэл 19 сая үлдэгдэл өртөг нь 98 сая, эд хогшил 72 сая, элэгдэл 9, үлдэгдэл өртөг нь 32 сая компьютер дагалдах хэрэгсэл 35 сая, элэгдэл 17, үлдэгдэл өртөг нь 17,6 сая, Барилга байгууламж 2,7 тэрбум төгрөгөнд нийт 16 ширхэг улсын бүртгэлийн гэрчилгээ, нийт 39 объект, авто зогсоол, инженерийн шугам хоолой бүртгэгдсэн байна. Машин тоног төхөөрөмжинд 137 сая төгрөгөнд дулааны халаалтын цогц төхөөрөмж, дулааны тоолуур, лифт зэрэг бүртгэгдсэн байна. 2015 оны 3 сарын 2-ны өдөр санхүүгийн зохицуулах хорооноос тус компанид шалгалт явуулж компанийн хөрөнгө, компанийн эзэмшилд байгааг холбогдох байгууллагаас тодруулж баталгаажуулсан. Энэ шалгалтаар ямар нэгэн зөрчил гараагүй болно. Барилга

байгууламжийг зургаар харуулсан байгаа. 16 объект гээд байгааг 16 улсын бүртгэлийн гэрчилгээ манайд байгааг андуураад байна.

- Бидисек- Батбаяр гуайг яриад байгаа 16 нь дөчийн хэд дотор байгаа юм уу
- Алтанзул- дөчийн хэд гэдэг нь нийтдээ нийт объект граш объектууд орсон.
- Батбаяр- чи битгий буруу тайлбар хийгээд бай.
- Алтанзул- Уучлаарай би тайлбарлах ёстой. Эсвэл та тайлбарлах юмуу.
- Батбаяр- би тайлбарлая.
- Алтанзул- болно болно. Та үндсэн хөрөнгөө мэднэ шүү дээ.
- Батбаяр- Чи сууж бай.
- Алтанзул- Та хэнээс асуумаар байгаа юм бэ
- Долгормаа- 11 объектийг нэгтгээд цогцолбороороо бүртгэсэн байгаа.
- Бидисек- Энэ чинь бүгдээрээ хорооны шалгалтаар ороод "Гутал" хувьцаат компаний нэр дээр баталгаажсан юм байна.
- Алтанзул- ороод баталгаажсан байгаа. Бүрэн хэмжээний шалгалт сарын хугацаанд
- Батбаяр- Бичиж байгаа биз баталгаажсан гээд байгааг би одоо унших гээд байна. Шалгалтын материалыг дараа нь уншъя. Энэ шалгалтыг Алтанзул дутуу танилцуулаад байна. Тийм биш ээ. 1999 оноос хойш үндсэн хөрөнгийн талаар гээд бусдад худалдсан гээд. Үүнийг хувьцаа эзэмшигчдэд интернетээр мэдэгдэх хэрэгтэй. Өнэ шалгалтан дээр санхүүгийн зохицуулах хороо улсын хөрөнгийн бүртгэлийн газарт хандсан. 1999 оноос хойш одоо Гутал ХК-нд ямар ямар объектууд нь байна.
- Долгормаа- Худлаа яриад байх юм аа. Миний гаргасан тайланг тэд нар шалгаад зөв байгаа гэсэн дандаа худлаа ярина. Ямарч зөрчилтэй холбоотой юм байхгүй дуугай бай.
- Батбаяр- маш их зөрчил байна.
- Долгормаа- өөрийнхөө дүгнэлтээ чи ярь за юу.
- Батбаяр- энэ тамга дарсан. Энийг ердөө ярихгүй байна.
- Долгормаа- арван дөрвөн зөрчилд байхгүй за юу
- Батбаяр- арван зургаа байна арван зургаа.Энд Долгормаа ерөнхий менежер, Ц.Төмөр ерөнхий захирал,
- Долгормаа- Энэ зөрчил биш ээ дүгнэлт. Дандаа чиний гаргасан.
- Батбаяр- худалдаад авсан гэж энэ дээр байж байгаад 500,000 төгрөгөөр авсан.
- Долгормаа- Худлаа яриад байх юм.
- Батбаяр- за больё. Энийг өөр газар тайлбарлая.



- Долгормаа- би энийг өөрөө өөртөө зарсан юм. Чи тэр ТУЗ-ийн тогтоол дээр тавьсан гарын үсгээ эргүүлж байж.
- Батбаяр- за больё.
- Долгормаа – Би саналаа хэлье за юу. ТУЗ-ийн даргыг 1998 оноос хойш Батбаяр өөрөө, хүүхдүүд нь Батбаярын гэр бүл тасралтгүй даргалаад явсан. Батбаяр, Батхишиг, Цэнд, Баттулга
- Батбаяр- 1998 онд эд нар чинь жоохон хүүхдүүд байсан. Би их хурлын гишүүн байсан. 18 жил би ердөөсөө орж ирээгүй.
- Долгормаа- 1998 оноос ТУЗ-ийн даргын үүргийг Батбаяр болон түүний гэр бүлийхэн хийсэн.

2рт Үл хөдлөх хөрөнгийг зарагдсан юм уу бүгд тогтоолтой тогтоол дээр гэр бүлийнхэнийх нь гарын үсэг бий. Энэ улсууд мөнхийн "Гуталыг шантаажилдаг тогтоол дээрээ өөрсдөө гарын үсгээ зурчихаад хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар оруулсангүй гээд байгаа.

Батбаяр- өөр асуудалдаа орёё. Санал авах ажилаа эхэлж сонгууль явуулья.

Дүн:

1рт Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-н дүгнэлт. Зөвшөөрсөн 51,35 хувьтай, татгалзсан 48,65 хувьтай

2рт Компанийг 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт. Зөвшөөрсөн 51,35 хувь, татгалзсан 37 хувь, түтгэлзсэн 11,65 хувь

3рт 2014 оны ноогдол ашгийг батлах. 48,65 % зөвшөөрсөн, татгалзсан 51,35 хувь

4рт Компанийн үндсэн хөрөнгийг өнөөгийн байдалтай танилцаж батлах зөвшөөрсөн 51,35 хувь, татгалзсан 48,65 хувь

ТУЗ-н 2015 оны төсөв батлах, зөвшөөрсөн 100 хувь

## “ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар: 003

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ын гишүүд сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 болон болон 62.1.13 дахь хэсэг болон 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн тооллогын комиссын 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

I. <u>М.Томар</u> .....	II. <u>Б. Батбаяр</u> .....
III. <u>Ч. Дэлориаа</u> .....	IV. <u>Б. Батхшигч</u> .....
V. <u>Т. Дарима</u> .....	IV. <u>Б. Баттор</u> .....

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

I. <u>Х. Амгай</u> .....	II. <u>О. Буянаах</u> .....
III. <u>Б. Бувач</u> .....	

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

4. “Гутал” ХК-ийн 2015 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг хавсралт 1-ээр 100%-тай баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б. БАТБАЯР



**"ГУТАЛ" ХК-ийн 2015 оны 04-р сарын 30-ны**  
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
Хурлын .... тоот тогтоолын хавсралт 1

**"Гутал" ХК-ийн ТУЗ-ийн 2015 Оны Зардлын Төсөв**

№	Зардал	Сарын цалин /төгрөгөөр/	Тоо	БҮГД /төгрөгөөр/
1	ТУЗ-ийн дарга	3 000 000	1	36 000 000
2	ТУЗ-ийн гишүүн	800 000	8	76 800 000
3	ТУЗ-ийн н.б.дарга	800 000	1	9 600 000
4	ТУЗ-ийн бичиг хэргийн зардалд	Жилд		2 700 000
	ДҮН			125 100 000

